Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газар 2013 онд батлагдсан 4 бүлэг 71 зүйлтэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 257,379.7 мянган төгрөгөөр буюу 13,6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	-	147,921.5	147,921.5
Бараа материал	88,292.4	165,557.4	77,265.0
Мал амьтад	8,850.0	8,850.0	-

Үндсэн хөрөнгө	1,785,775.4	1,817,968.7	32,193.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,882,917.8</b>	<b>2,140,297.5</b>	<b>257,379.7</b>
Өр төлбөр	78,541.5	111,676.6	32,835.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,804,076.2	2,028,620.9	224,544.7
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,882,917.8</b>	<b>2,140,297.5</b>	<b>257,379.7</b>

Дээрх хүснэгтээс харахад: Авлага дансны оны эцсийн үлдэгдэл 147,921.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь НДШ 927.7 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардалд 593.8 мянган төгрөгийг тус тус илүү төлсөн, Флай хай ХХК-ийн дуусгаагүй ажлын гүйцэтгэлд 46,400.0 мянган төгрөг, төрийн албан хаагчдын орон сууц барих гэрээгээр 100,000.0 мянган төгрөгийг Цолмон сүндэр ХХК-д шилжүүлснээс шалтгаалжээ.

Бараа материал дансны эхний үлдэгдэл 88,292.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 165,557.4 мянган төгрөг буюу худалдан авсан болон хандивын хөрөнгө 77,265.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 1,785,775.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1,817,968.7 мянган төгрөг болж, 32,193.3 мянган төгрөг буюу төсвийн хөрөнгөөр худалдан авсан болон үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 27,441.6 мянган төгрөгийн барилга байгууламж, 14,988.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 31,455.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 53,732.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 9,124.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 70,700.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил үнэ төлбөргүй хүлээн авч үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

Тайлант онд өр төлбөр дансны эхний үлдэгдэл 78.8 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 111,676.0 төгрөг болж 32,835.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 2022 онд Эко Энержи ресурс ХХК-ийн гүйцэтгэсэн сумын гэр хороолол, нийтийн орон сууц, үйлчилгээний газруудыг төвлөрсөн халаалтад холбох зардлын санхүүжилтийн үлдэгдэл байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,028,620.9 мянган төгрөг болж 224,544.7 төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 401,431.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас Төв аймгийн Баян-Өнжүүл сумын сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 5 дугаар тогтоолоор Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны зардлыг 44,748.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 446,180.2 мянган төгрөг, шилжих үлдэгдлээс хөрөнгө оруулалтын зардалд 80,000.0 мянган төгрөгөөр нийт 526,180.2 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төслийн саналаас Төв аймгийн Баян-Өнжүүл сумын сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 03 дугаар тогтоолоор тайлант оны ЗДТГ-ын үйл ажиллагааны зардлыг 71,126.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 597,306.8 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын сумын Засаг даргын Тамгын газрын төсвийг тодотгон батлахдаа урьд оны шилжих үлдэгдлээс санхүүжих 80,000.0 мянган төгрөгийг анхны болон тодотгосон тогтоолд давхардуулан тусгасан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 597,306.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 597,306.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үндсэн үйл ажиллагааны орлого 25,290.8 мянган төгрөг, гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээний зардал 3,184.5 мянган төгрөг, баг хорооны үйл ажиллагааны зардал 109.4 мянган төгрөг, бусад зардлаас 2,650.4 мянган төгрөг, орон нутгийн нөөц хөрөнгө 10.0 мянган төгрөг, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал 15,513.4 мянган төгрөг нийт 46,758.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 550,548.3 мянган төгрөг буюу 92,2 хувьтай байгаа нь үйл ажиллагааны зардлын төсвийг 44,108.1 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын зардлыг 2,650.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-үндсэн үйл ажиллагааны зардал	339,670.7	314,379.9	25,290.8	92,6
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээ	50,915.5	47,731.0	3,184.5	93,7
3	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-баг хорооны үйл ажиллагааны зардал	62,520.6	62,411.2	109.4	99,8
4	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	1,000.0	1,000.0	0.0	100,0
5	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-бусад хөрөнгийн зардал	95,000.0	92,349.6	2,650.4	97,2
6	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Орон нутгийн нөөц хөрөнгө	5,000.0	4,990.0	10.0	99,8
7	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Улсын их баяр наадмын зардал	5,000.0	5,000.0	0.0	100,0
8	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал	35,000.0	19,486.5	15,513.5	55,7
9	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Хур хог хаягдал, орчны бохирдлын зардал	3,200.0	3,200.0	0.0	100,0
	Дүн	<b>597,306.8</b>	<b>550,548.2</b>	<b>46,758.6</b>	<b>92,2</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны захирагчаас наадмын санхүүгийн дэмжлэгт 5,000.0 мянган төгрөг, спорт чийрэгжүүлэлтийн санхүүжилт 58,000.0 мянган төгрөг, орон нутгийн нэмэгдэлд 23,619.4 мянган төгрөг, хагас жилийн мал тооллогын зардалд 857.2 мянган төгрөг, ТАХ-ыг орон сууцаар хангах ажлын эцсийн санхүүжилт 100,000.0 мянган төгрөг, өвс, тэжээлийн үнэнд 28,200.0 мянган төгрөг, нийт 215,676.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газар тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 17,746.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 179,600.0 мянган төгрөг нийт 197,346.9 мянган төгрөг зарцуулж мал тооллого 353.4 мянган төгрөг, өвсний 4,129.0 мянган төгрөг, орон нутгийн нэмэгдэл 2,247.3 мянган төгрөг, спорт чийрэгжүүлэлтийн санхүүжилт 11,600.0 мянган төгрөг нийт 18,329.7 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	/мянган төгрөгөөр/	
					Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01-2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 94,4%	559,106.8	527,861.7
2	71411-Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	2023.01.01-2023.12.31	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээ	Хөтөлбөрийн хэрэгжилт 59.4%	38,200.0	22,686.5

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 36,954.0 мянган төгрөгийн бичиг хэрэг, шатахуун, эд хогшил, шуудан холбооны зардлыг шууд байгуулах аргаар, ерөнхий гэрээгээр 100,000.0 мянган төгрөгийн төрийн албан хаагчдын орон сууц барихаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 31,403.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг шууд худалдан авалтаар хийсэн байна.

Төрийн албан хаагчдын орон сууц барих 100,000.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагаа, тендерийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт зохион байгуулсан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн цахим дэлгүүрээс бараа худалдан авахтай холбоотой зөвлөмж өгсөн байна.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/37 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2023 оны төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлын суурь үзүүлэлтийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлагдсан 2023 оны төсвийн 677,306.8 мянган төгрөгийн нийт зардлын 1,0 хувиар буюу 6,773.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,741.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд 100 хувь, 5,0 саяас дээших орлогын 11 гүйлгээ, зарлагын 2 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг тус тус мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газрын эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар мөнгөн урамшуулал, шатахууны тайлан гаргахдаа жолоочийн тооцоо бодоогүй, шилэн данстай холбоотой 4 зөвлөмж өгөгдсөнөөс 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй 93,0%-тай Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 6 дугаар сарын 14-ны өдрийн 01/167 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	3	410,464.8	3	381,861.4	93,0
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>410,464.8</b>	<b>3</b>	<b>381,861.4</b>	<b>93,0</b>

Өмнөх оны аудитаар шатахууны тайлан гаргахдаа жолоочийн тооцоо бодоогүй байсан зөвлөмж өгөхөд тайлант онд хэрэгжүүлж ажиллаагүй тул албан шаардлага бичихээр боллоо.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагад дараагийн аудитаар хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байгаа ажлын гэрээ, гүйцэтгэлийг Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 282 тоот тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.12-д “төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно” гэж заасны дагуу санхүүжүүлсэн эсэхийг авч үзэх.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт 597,306.8 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 597,306.8 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

1. Тус байгууллага тайлант оны төсвийн гүйцэтгэлийн тайланг 597,306.8 мянган төгрөгөөр тайлагнаж ирүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 189,857.3 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 112,071.9 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 46,400.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 31,403.4 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлээ.

#### 5.1 Төлбөрийн акт

1.Тус байгууллага тайлант онд НДШ-д 927.6 мянган төгрөг, гэрэл цахилгааны 593.8 мянган төгрөгийн нийт 1,521.4 мянган төгрөгийн илүү төлөлттэй гарсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, НББТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

2.Тус байгууллага тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны захирагчаас орон нутгийн төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлэхээр 100,000.0 мянган төгрөгийг ирүүлсэн байна. Гэтэл төрийн албан хаагчдын орон сууц баригдаж эхлээгүй, ямар ч ажлын гүйцэлтгүй байхад Цолмон сүндэр ХХК-д гэрээний үнийн дүнгийн 100,000.0 мянган төгрөгийг 100 хувь шилжүүлсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-т “төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх”, Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.8.13-т “Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр санхүүжих төсөл, арга хэмжээний урьдчилгаа төлбөрийн нийт хэмжээ нь тухайн онд батлагдсан нийт санхүүжилтийн 30 хувиас ихгүй байна” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

3.Тайлант онд Төв аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн Б/02 тоот “Төрийн албан хаагчдын ангилал зэрэглэл цалин хөлсийг шинэчлэн тогтоож, орон нутгийн нэмэгдэл олгох тухай” захирамж, Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн “Төрийн албан хаагчдын ангилал, зэрэглэл шинэчлэн тогтоож орон нутгийн нэмэгдэл олгох тухай ” Б/03 захирамжаар Улс төрийн 5 албан хаагчийн орон нутгийн нэмэгдэлд 9,682.5 мянган төгрөг олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 489 дүгээр “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоол, 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар “Журам батлах тухай” тогтоол болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

4.Тайлант онд ЗДТГ-ын даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Б/36 тоот “Үр дүнгийн урамшуулал олгох тушаалаар” ажилд ороод удаагүй байгаа Б.Нямсүрэнд үр дүнгийн урамшуулал 100% буюу 868,000.0 мянган төгрөг олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалт болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

## **5.2 Албан шаардлага**

1.Тус байгууллага тайлант онд Флай хай ХХК-тай 2023 оны 7 дугаар сарын 03-ны өдөр №ТӨАОНӨГ/2023/2034 тоот 58,000.0 мянган төгрөгийн үнийн дүнтэй 2023 оны 7 дугаар сарын 20-нд ашиглалтад хүлээлгэж өгөх ажлын гэрээ байгуулж, ажил эхлээгүй байхад гүйцэтгэлийн 80 хувь болох 46,400.0 мянган төгрөгийг шилжүүлсэн, мөн гэрээний хугацаанд ажил хүлээлгэж өгөөгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-т “төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.8.13-т “Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр санхүүжих төсөл, арга хэмжээний урьдчилгаа төлбөрийн нийт хэмжээ нь тухайн онд батлагдсан нийт санхүүжилтийн 30 хувиас ихгүй байна” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

2.Тус байгууллага шатахууны тайлан гаргахдаа жолоочийн тооцоо бодож байх өмнөх оны санхүүгийн аудитаар өгсөн зөвлөмжийг хангаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” заасныг болон

Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

## 5.4 Зөвлөмж

### 2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

Тус байгууллага тайлант онд 5 аж ахуй нэгж байгууллагаас 31,403.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.13-т “Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр этгээдээс худалдан авахыг хориглоно” гэсэн заалтыг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Цахим дэлгүүрийн бараанаас худалдан авалт хийж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		/мянган төгрөгөөр/	
					Үүнээс	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайланг тайлагнаж ирүүлээгүй	1	597,306.8	1	597,306.8	1	597,306.8
Дүн	1	597,306.8	1	597,306.8	1	597,306.8

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд НДШ, гэрэл цахилгаанд илүү төлөлттэй гарсан.	1	1,521.4	1	1,521.4				
Төрийн албан хаагчдын орон сууц баригдаж эхлээгүй, ямар ч ажлын гүйцэлтгүй байхад Цолмон сүндэр ХХК-д гэрээний үнийн дүнг 100% шилжүүлсэн байна.	1	100,000.0	1	100,000.0				

Тайлант онд Флай хай ХХК-тай ажил эхлээгүй байхад гүйцэтгэлийн 80% шилжүүлсэн, мөн гэрээний хугацаанд ажил хүлээлгэж өгөөгүй байна	1	46,400.0				1	46,400.0		
Шатахууны тайлан гаргахдаа жолоочийн тооцоо бодож байх өмнөх оны санхүүгийн аудитаар өгсөн зөвлөмжийг хангаагүй зөрчил илэрлээ.	1	0				1	0		
Тайлант онд 5 аж ахуй нэгж байгууллагаас тоног төхөөрөмж, тавилга эд хогшил тус тус худалдан авсан байна	1	31,403.4						1	31,403.4
Төв аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн Б/02 тоот захирамж, Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн "Төрийн албан хаагчдын ангилал, зэрэглэл шинэчлэн тогтоож орон нутгийн нэмэгдэл олгох тухай" Б/03 захирамжаар Улс төрийн 5 албан хаагчийн орон нутгийн нэмэгдэл олгосон зөрчил илэрлээ.	1	9,682.5	1	9,682.5					
4.Тайлант онд ЗДТГ-ын даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Б/36 тоот "Үр дүнгийн урамшуулал олгох тушаалаар" ажилд ороод удаагүй байгаа Б.Нямсүрэнд үр дүнгийн урамшуулал 100% олгосон зөрчил илэрлээ	1	868.0	1	868.0					
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>189,857.3</b>	<b>4</b>	<b>112,071.9</b>		<b>2</b>	<b>46,400.0</b>	<b>1</b>	<b>31,403.4</b>